



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/216

Номгон

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/215 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 29 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тохиолдол тус аймагт нэмж бүртгэгдэж, эх үүсвэрүүдийн хавьтлуудыг тогтоохын тулд тандалт судалгааг зохион байгуулах, зөөвөрлөгдөн орж ирсэн халдварын голомтыг тогтоох, цаашид тархалтыг зогсоох зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 24.00 цаг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, ус усан хангамж түгээх цэгүүд, эрчим хүч, хүнс үйлдвэрлэл, хүнсний дэлгүүр, супер маркет, шатахуун түгээх станцаас бусад бүх төрийн байгууллага, болон аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосугай.

3. Дээрх хугацаанд коронавируст халдварын тандалт судалгааг хийж, хавьтлуудыг шуурхай тогтоох зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Тагнуулын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн, (дэд хурандаа Р.Мэндбаяр), Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Н.Энхжаргал) нарт;

4. Үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг халдвар хамгааллын дэглэм сахиулж, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, нэгдсэн удирдлага зохион

1210541


2.

байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын Нарийн бичгийн дарга, Шуурхай штабын дарга (дэд хурандаа Э.Батбаяр)-д;

5.Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан халдварын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуваарь гарган төрийн байгууллага болон аж ахуй нэгжүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэж халдвар хамгааллын дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Н.Бямбадорж)-д;

6.Коронавируст халдварын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг харьяа сум орон нутагтаа холбогдох дүрэм журмын дагуу халдвар хамгааллын дэглэмийг хангуулж, нутаг дэвсгэрийн хэмжээнд шуурхай удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН